

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-06-24

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 07 дугаар сарын 01-ний “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.
- 8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
- 8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
- 8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
- 8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын ажлын уялдаа холбоог нэгдсэн төлөвлөгөөний дагуу сайтар хангаж, газар дээр нь явж танилцан, холбогдох ажлуудыг гүйцэтгэх.	ЗДО Х.Цогцэцэг, Ажлын хэсгүүд, Соёлын ордон
2	“Хотын иргэдийн баяр-Хүрээ даншиг” наадмын бэлтгэлийг ханган иргэд, олон нийтийн аюулгүй байдал, худалдаа үйлчилгээнд онцгой анхаарч оролцох.	НХХ, Соёлын ордон, БТСХ
3	Нийслэлд төсвийн тодотгол хийгдэхтэй холбогдуулан дүүргийн зүгээс холбогдох саналуудыг нэгтгэн хүргүүлэх.	ЗДО Х.Цогцэцэг, СТСХ
4	Хороодын Засаг дарга нартай уулзсан уулзалтаар өгсөн үүрэг даалгаврыг эзэнжүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	ТЗУХ, Хороод, холбогдох чиг үүргийн байгууллагууд
5	Дүүргийн чиг үүргийг хороодод шилжүүлэхтэй холбоотой бүтцийг судалж танилцуулах.	ТЗУХ
6	Хөрөнгө оруулалтын ажлуудаас удаашралтай буюу зогссон ажлуудын жагсаалтыг гаргаж, магадлал, дүгнэлт, акт гаргаж, гэрээг цуцлах ажлуудыг танилцуулах.	СТСХ, Ажлын хэсгүүд, Ашиглагч байгууллагууд
7	Газрын дуудлага худалдаа зохион байгуулах бэлтгэл ажлуудыг сайтар хангах.	ГЗБА
8	Төсвийн орлогын биелэлтийг жигд хангах.	Татварын хэлтэс
9	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар авах шинэ аргачлалын талаар судалж, танилцуулах.	
10	2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженерийн шугам, сүлжээний ажлуудыг эрчимжүүлэх.	ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
11	Нийслэлийн Байгаль орчны газраас хог хаягдлын Улсын байцаагчийн сонгон шалгаруулалтыг зарласан тул дүүргүүд хүмүүсээ оролцуулах.	ЗДТГ
12	Дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй “Сүү хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг танилцуулах.	НХХ, ЕБС, СӨББ-ууд
13	Замын хөдөлгөөний дүрэм, журам зөрчиж буй тээврийн хэрэгслийг холбогдох хуулийн хүрээнд арга хэмжээ авах ажлыг эрчимжүүлэх.	ЦХ-ийн ЗЦХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
14	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгүүд болон Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын байнгын ажиллагаатай ажлын хэсгүүд хамтран хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудад хяналт тавьж, гүйцэтгэлийг Үндэсний их баяр наадмаас өмнө эрчимжүүлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц СТСХ, Ажлын хэсгүүд
15	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хүрээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг сайтар хангаж ажиллах.	Чиг үүргийн хүрээний байгууллагууд, Нийт байгууллагууд
16	Ногоон байгууламжийн усалгааг тогтмолжуулан, хэлбэржүүлэлт хийх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, нийт

		байгууллагууд
17	Байрнуудын дээрх туузан гэрэл болон нуман хаалганы гэрэлтүүлгийн өнгө үзэмжийг сайжруулах, засварлах, 6-р байрнаас хүүхдийн тоглоомын талбай руу явах хэсэгт гэрэл шинээр байрлуулж, аюулгүй байдлыг хангах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
18	Цагдаагийн постноос төмөр замын гарам хүртэлх ногоон байгууламжийн хайс хашааны дотор талыг будах, усны савнуудыг будаж цэгцлэх ажлыг гүйцэтгэх.	
19	Дүүргийн хэмжээнд тоос, тоосонцроос урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайг усалж, чийгшүүлэх ажлыг сайтар зохион байгуулах.	
20	Баяр наадмын үеэр ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийг томилгоожуулан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг тус жижүүрийн үүрэг гүйцэтгэхэд татан оролцуулж, хуваарийн дагуу ажиллуулан аюулгүй байдлыг хангуулах.	ОБХ
21	Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салаа төмөр замын бүтээн байгуулалтын ажил эхэлсэнтэй холбогдуулан 06 дугаар сарын 26-ны өдрийн 09:00-19:00 цагт төмөр замын гарам хаах тул чиг үүргийн байгууллагууд бэлтгэл бэлэн байдлаа ханган ажиллах.	Хэвлэл мэдээллийн ажилтнууд, Чиг үүргийн байгууллагууд
22	Дүүргийн баяр наадмын үеэр 07 дугаар сарын 09-ний өдөр “Туг, далбаа” мандуулах ёслолын арга хэмжээнд оролцогчдын бэлтгэл, бэлэн байдлыг сайтар хангаж ажиллах.	Цэргийн штаб
23	Насанд хүрээгүй иргэнд архи согтууруулах ундааны зүйл худалдан борлуулсан талаарх мэдээллийг олон нийтэд анхааруулж, түгээх ажлыг зохион байгуулах.	Хэвлэл мэдээллийн ажилтнууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР